

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-12

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/	4-12
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 09-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Очирбат;

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Б.Жавхлан, Д.Жаргалсайхан.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10.5-д шалгалтын явцад гишүүний ёс зүйн зөрчлийн шинж байдал нь ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Байнгын хорооны дарга тухайн гишүүнийг дуудаж уулзаж зөвлөгөө өгнө гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара гишүүнд Байнгын хорооны гишүүн Б.Хэрлэнгийн хамтаар зөвлөгөө өгч асуудлыг шийдвэрлэсэн тул хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт байгаа “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолыг төслийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасъя гэсэн горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа санал хэлэв.

Б.Баярбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 0

Бүгд: 7

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дарааллаас “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолыг төслийг хасав.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны даргын үүрэг болгосноор Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй холбоотой мэдээлэл болон ёс зүйн хариуцлага тооцох саналыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хариулж, тайлбар хийв.

“Ёс зүйн хариуцлага тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар Байнгын хорооны даргын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.7.3 дахь заалтыг зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулгад уг дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг баримтлан албан тушаалын цалингийн хэмжээг “3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах сахилгын хариуцлагыг ногдуулсугай” гэснийг “6 сарын хугацаанд 20 хувиар бууруулах сахилгын хариуцлагыг ногдуулсугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 3
Бүгд: 7
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнг дэмжсэнээр тооцож, 71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар тогтоолын төслийг танилцуулав.

Б.Баярбаатар: “Ёс зүйн хариуцлага тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 2
Бүгд: 8
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнг дэмжсэнээр тооцож, 87.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 14 цаг 24 минут.

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. 14 цаг 25 минут болсон байна. Ирц хүрсэн учраас өнөөдрийн хурлыг эхлүүлэе. Баярмагнай овогтой Баярбаатар ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна, Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь, гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, гишүүн Доржзодовын Энхтуяа гэсэн 3 гишүүн АН-ын бүлэг дээр байгаа бол ҮАБЗ дээр мэдээлэл хийхээр хурлаас тус тус чөлөө авсан байна аа.

Ингээд ирц хүрч 58.3 хувиар ирц хүрсэн тул өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье ээ. Хэлэлцэх асуудал танилцуулна.

Хоёр асуудал хэлэлцэхээр өнгөрсөн 7 хоногоос гарсан даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр 2 асуудал хэлэлцэхээр Байнгын хорооны төсөлд суусан байгаа.

Ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай байнгын хорооны тогтоолын төсөл,

Хоёр мөн Ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөгөөнд туссан.

Хурал даргалагчийн зүгээс горимын санал гаргах гэж байна. Би өнөөдөр Байнгын хорооны гишүүн Хэрлэн гишүүнтэй хамт Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Наратай бас уулзалтыг хийлээ. Ер нь бол 2025 оны 3 сарын 28-ны өдөр баялагтаа Эзэн Монгол ТББ-ын тэргүүн Хажидмаагаас Нарантуяа-Нара гишүүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүнээс нь эгүүлэн татах хүртэл арга хэмжээ авах ийм гомдлыг ирүүлсэн. Гомдлын агуулга дээр бол цахим орчинд ёс бус үг хэрэглэсэн, цахим орчинд бусадтай маргалдсан энэ тэр гэсэн иймэрхүү зүйлүүдийг бол хавсаргасан байсан. Тус хүнд бол иргэнд тухайн өдөрт нь хариултыг албан бичгээр би хүргүүлсэн. Яагаад гэвэл өнөөдөр Ёс зүйн дэгийн байнгын хорооны хамрах хүрээнд энэ Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах асуудал бол манай Байнгын хорооны хамрах асуудал биш юм гэдэг агуулгаар албан бичгээр хариуг нь явуулсан.

Нарантуяа-Нараа гишүүнтэй уулзаж нөхцөл байдлын талаар ирсэн гомдлын талаар танилцуулж өөрөөс нь бас хариу тайлбарыг авсан. Өөрөө бол бас үндэслэлтэй тайлбаруудаа бол хурлын протоколд тэмдэглүүлж бид нарын уулзалтад үлдээсэн байж байгаа. Ингээд Хэрлэн гишүүн бид 2 ярилцаж тохироод 10.5 Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10.5 дээр шалгалтын явцад

гишүүний ёс зүйн зөрчлийн шинж байдал нь ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Байнгын хорооны дарга тухайн гишүүнийг дуудаж уулзаж зөвлөгөө өгнө өө гэж байгаа юм. Ингээд би Нарантуяа-Нара гишүүнд холбогдох зөвлөгөөг өглөө. Ер нь бол цаашид манай Ёс зүйн дэгийн байнгын хороон дээр 2 хүний хоорондоо ам зөрсөн асуудлыг дахиж авч хэлэлцэхгүй ээ.

Хэлэлцэх ёсгүй тэр тусмаа цахим орчинд. Өнөөдөр энэ Улсын Их Хурлын гишүүн, энэ Байнгын хорооны танхим, энэ парламентын танхим, энэ төрийн ордонд биеэ авч явж байгаа байдал энэ хурал чуулганы нэгдсэн байдал дээр бид хандаж байгаа хандлага дээр нь бид нар асуудал ярина уу гэхээс биш хаана ч хэнтэй ч очоод хүн өнөөдөр ам мурийх зүйл гарч болно. Байр сууриа илэрхийлэх нөхцөл байдал гарч болно. Тэгэхдээ байр сууриа илэрхийлэхдээ харилцаан дээрээ өндөр түвшинд анхаарахыг Нарантуяа-Нара гишүүнд Хэрлэн гишүүн бид 2-ын зүгээс бол ингээд зөвлөгөөг өгсөн. Өөрөө бас зөвлөгөөг нэлээн ойлгож хүлээж авсан гэдгээ бол илэрхийлсэн. Ийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудлаас би энэ 2 дахь асуудал буюу энэ ёс зүйн хариуцлага тооцуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг хасах горимын саналыг оруулж байна.

Дэгийн тухай хуулийн 13.1.4-д горимын санал гаргасан бол горимын саналаар санал хурааж шийдвэрлэнэ гэсэн дэг байгаа. Ингээд 2 дахь асуудал буюу хэлэлцэх асуудлаас Ёс зүйн хариуцлага тооцох тухай тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас хасах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Асууж болно. Горимын саналтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрээ өгөөрэй.

Аюушийн Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

Баярбаатар Байнгын хорооны дарга болон Хэрлэн гишүүдийн горимын саналыг дэмжиж байна. Дашрамд гэхдээ бас нэг хэлэх зүйл байгаа нь юу вэ гэхлээр Улсын Их Хурлын тухай хууль байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 44.1.11 дээр Улсын Их Хурлын гишүүнд хориглох зүйл заалтуудыг тусгайлаад заагаад өгчихсөн байгаа. үүн дээр юу гэж байна вэ гэхээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ байнгын дэд хянан шалгах түр хорооны болон нэгдсэн хуралдаанд эс үгүй бол хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж доромжлох нь хориглосон зүйл.

Ийм учраас хүн хувиараа ч бай хаана ч бай гэсэн асуудал бол Улсын Их Хурлын гишүүний хувьд бол байх боломжгүй ээ. Яагаад гэвэл бүрэн эрхээ хэрэгжүүлж байхдаа гэдгээр тангараг өргөснөөс хойш дараагийн гишүүн ээлжит сонгуулийн дараагаар тангараг өргөх хүртэл бүрэн эрхийн хугацаа явж байгаа учраас энэ хугацаандаа бүрэн эрхээ хэрэгжүүлж байна гэж ойлгоно. Та Улсын Их Хурлын гишүүн мөн л юм бол тангараг өргөсөн л юм бол та бусадтай тэвчээртэй, хүлээцтэй, ёс зүйтэй байх үүргийг хуулиар хүлээж байгаа шүү.

Би Нарантуяа-Нара дээр энийг ярих гээгүй. Энэ нийт 126 гишүүнд хамааралтай асуудал шүү. Ер нь нөгөө Нарантуяа-Нара маань хөөрхий нөгөө олон нийтэд ийм нээлттэй, олон нийтийн хараан доор байдаг учраас гэж онцолж хараад байх шиг байна. Гэтэл Нарантуяа-Нарагаас гадна өөр бусад хүмүүс хүртэл Ордонд хүртэл зодолдсон юм уу, зодолдоогүй юм уу, цохисон юм уу, цохиомгүй юм уу нэг үл ойлгогдох нөхцөл байдал хүртэл гарч байна шүү дээ. Ийм учраас бид нар

нэгэнтээ л ёс зүйг сахих ёстой гэж байгаа юм бол аливаа асуудал дээр бас хэн нэгнийг онилж биш нийт гишүүдийн хувьд бол ярих ёстой гэдэг агуулгаар бусдыг хуралдаанаас гадуур гэдэг чинь бүхий л хугацааг хэлж байгаа шүү дээ. Бусдыг гүтгэх доромжлох нь бол хориглосон байдаг юм аа. Ёс зүй, дэгийн байнгын хороогоор хоорондоо хэн нэгнийгээ доромжилсон асуудлыг оруулдаггүй юм гэхэд тухайн асуудал чинь шүүхийн өмнө хүртэл очих боломжтой юм шүү гэдгийг өнөөдөр энэ дашрамд бас хэлэхийг хүсэж байна аа. Тэгээд хасахыг бол дэмжиж байна. Наратай холбоотойгоор бидний хамгийн анхны шийдвэр маань ч гэсэн бас Наратай холбоотой гарч байсан. Яахын аргагүй бид нар нэг эмэгтэй хүнийг л онилоод байгаа юм шиг муухай харагдаж байгаа асуудал байгаа. Гэхдээ тус гишүүн маань ч гэсэн өнөөдөр эхний сануулга нь юун дээр байсан бэ гэдэг дээрээ ч гэсэн бас эргээд харах нь зүйтэй гэдгийг бас ташрамд хэлэх гэсэн юм аа.

Тухайн үед сошиал хаягаараа дамжуулаад бараа бүтээгдэхүүн сурталчилж орлого олж байна энэ чинь буруу юм гэж бид нар сануулах арга хэмжээ өгч байсан шүү дээ тэ. Тэгэхээр тэр сошиал хаяг нь хэвээрээ байгаа. Өөрөө дэлгэцэд харагдахгүй ч гэсэн нөхөр нь энэ бараа сурталчилгаа хийж байгаа нь миний хувьд бол энэ сануулах арга хэмжээг бүрэн гүйцэд биелүүлэхгүй байгаа юм шиг санагдаж байгаа. Тэгээд нөхөр нь бол өөрөө өөр сошиал хаягаар нээгээд энэ асуудлаа явуулах нь бол нээлттэй шүү дээ. Ийм учраас бид хуулиа бас чанд сахиж мөрдөхирдөх нь зүйтэй юм аа.

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн санал хэллээ. Тийм Нарантуяа-Нара гишүүнтэй нэлээн дэлгэрэнгүй ярилцлага хийж бас энэ талаар нэлээн сайн ойлголтыг яг наад өмнөх сануулах арга хэмжээ буюу Байнгын хорооны тогтоол батлагдсан. Энэ тогтоол өнөөдөр хүчинтэй байгаа шүү дээ. Нэг жилийн хугацаанд хүчинтэй энэ сануулах арга хэмжээ. Тэр агуулгыг ч бас хэллээ. Хууль зөрчсөн нөхцөл байдлыг нь ч тухайн үед нь хууль зөрчсөн гэж гэхээсээ илүүтэй дүрэм зөрчсөн гэж би ярьж байгаа юм. Дүрэм зөрчсөн нөхцөл байдлыг нь бол хэлсэн. Хууль зөрчсөнийг бид нотлохгүй. Бид нарт тийм эрх байхгүй. Тэгэхээр дүрмийн хүрээнд асуудалд хандсан. Энэ асуудал өнөөдөр хэвээрээ байгаа шүү гэдгийг ойлгуулж хэлсэн. Тэгээд дараа дараадаа энэ асуудлууддаа нэлээн анхаараарай гэдэг зүйлийг ярьсан.

Дараагийн нэг асуудал нь Ариунзаяа гишүүн ярьсан учраас би хурал даргалагчийн зүгээс гишүүддээ мэдээлэл өгчихье. Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа, Наранбаяр гишүүнд зодолдсон гар хүрсэн, юу болсон тийм янз бүрийн ийм асуудлууд өнгөрсөн 7 хоногт нэлээдгүй олон шуугисан. Энэ талаар бол өөрсдөө зөрүүтэй мэдээллүүдийг 2, 3 удаа бас ярьсан байдаг. Тийм учраас өнөөдөр Байнгын хорооноос бас 2025 оны 4 сарын 7-ны өдөр тайлбар ирүүлэх тухай албан бичгийг хоёуланд нь явуулсан байж байгаа. Энэ Ариунзаяа гишүүний хэлж байгаа бас яг энэ үнэн. Өнөөдөр ямар ч үзэл бодол зөрж болно хүн.

Тэгэхдээ өнөөдөр энэ ухамсарт хүн бол учир зүйгээ хэл амаараа ололцож байх ёстой. Үзэл бодол зөрлөө гээд бусдын эрх чөлөөнд халддаг, биед халддаг, эрүүл мэндэд халддаг ийм байдал байж болохгүй. Гэтэл нөхцөл байдал юу гэх юм бараг харилцан цохисон бол зодоон болдогоо ч гэх шиг. Би зүгээр сууж байсан юм ч гэх шиг. Тэгэхээр зодоон биш эд нар гээд нэг ийм буруу зөрүү юм бас яриад байж болохгүй байхаа Улсын Их Хурлын гишүүд. Тэр тусмаа Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн хүн бас. Аливаа нэг зүйл дээрээ хариуцлагатай байх ёстой гэж харж байгаа. Тэгээд энэ тайлбар удахгүй ирэх байх. Энэ 15-ны дотор Байнгын хороонд

тайлбар ирүүлэхийг үүрэг болгочихсон байж байгаа. Тэгээд тайлбарыг ирэхээр би гишүүдэд танилцуулаад ер нь энэ асуудлыг бас дахиж бид нар ярих нь зөв өө гэж бодож байгаа.

Ингээд санал хураалтаа явуулъя. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалт 7 гишүүн санал хураалтад орж, 7 зөвшөөрснөөр 100 хувийн саналаар горимын санал л дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа орно. Өнгөрсөн чуулганы намрын чуулганы хаалтын хурал дээр манай Байнгын хорооноос Аюушийн Ариунзаяа гишүүнээр ахлуулаад энэ Улсын Их Хурлын гишүүдийн ирцтэй холбоотой асуудлыг судалж дүрэмд заасан 40 цаг буюу ажлын 5 өдөр нийлээд 40 цагийн энэ хурал тасалсан Улсын Их Хурлын гишүүнд хариуцлага тооцох саналыг оруулж ир гэдгийг Байнгын хорооноос үүрэг болгосон. Өнөөдөр ингээд энэ танилцуулгыг хийж бид нар тогтоолын төслөө танилцуулж хариуцлагын асуудлаа ярина.

Ингээд Ариунзаяа гишүүнд тухайн чиглэлийн дагуу хийсэн нэгтгэсэн мэдээллээ хийхийг хүсэж байна аа. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.7-д нэгдсэн хуралдааны ирцийн асуудал Ёс зүй, дэгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарна гэж заасан байдаг. Ийм учраас Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 21-ний хуралдаанаар Байнгын хорооны дарга Баярбаатар 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан 126 гишүүнтэй парламентын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны гишүүдийн ирцтэй холбоотой мэдээллийг гаргаж шаардлагатай бол Байнгын хорооны хуралдаанд оруулж танилцуулах үүргийг надаа өгсөн.

Улсын Их Хурлын тухай хуулийн 46.5.13-д гишүүн нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон ирцийн мэдээг сар бүр гаргаж олон нийтэд мэдээлэх гэж заасан. Улсын Их Хурлын гишүүн тус бүрээр нь өдөр, цаг, минутаар Хуралдаан зохион байгуулах хэлтсээс тусгайлан гаргадаг. Улсын Их Хурлын дарга Амарбаясгалангийн чиглэлээр тухайн өдөр бүрд нь бас энэ олон нийтэд нээлттэй мэдээлж байгаа ийм онцлогтой. Ирцийн мэдээг авч үзэхэд Монгол Улсын Их Хурлын 2024 оны анхдугаар, ээлжит бус намрын ээлжит чуулганыг авч үзсэн. Ингэхдээ хуулиараа тухайн жилийн ирцийг гэж үзэж байгаа учраас ээлжит чуулганы хугацаагаар биш харин тухайн жилийг 12 сарын 31-нээр тасалбар болгоно гэж үзэж 2024 оны ажлын сүүлийн өдөр буюу 12 сарын 27-ноор авч үзсэн байгаа. Тэгэхээр 2024 онд анхдугаар ээлжит бус намрын ээлжит чуулган 12 сарын 27-ыг хүртэл авч үзээд 162 цаг 49 минут нийт хуралдсан гэж үзээд Улсын Их Хурлын гишүүн Баттулга хамгийн олон буюу 67 цаг 20 минут тасалсан. Оролцоогүй буюу хүндэтгэн үзэх шалтгаан мэдүүлээгүй, эмнэлгийн чөлөө аваагүй, ямар нэг нэг тайлбар мэдээлэлгүйгээр тасалснаар бүртгэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар шинэ бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон ирцийг тасалсан цаг минутаар нь гаргаж олон цаг тасалсан хоцорсон гишүүд хэдийгээр 40 цаг хүрээгүй ч 40 цагаас дээш давах юм

бол хариуцлага тооцсоноо буюу ажлын 5 хоногийг давсан бол хариуцлага тооцох заалттай.

40 цагтаа хүрээгүй ч гэсэн анхаарах хэрэгтэй. Эхний 10 гишүүдийг бол гаргаж Баярбаатар даргын сануулах бичгийг бол бас тухайн үед хүргүүлсэн. 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр албан бичгээр та хуралдааны ирцдээ анхаараарай гэдэг ийм сануулах бичгийг бол хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Амгаланбаатар, Бат-Амгалан Батбаяр, Батлут, Баттулга, Ганбат, Лүндэг, Нарантуяа-Нара, Даваагийн Цогтбаатар 126 гишүүнээс эхний 10-д хамгийн олон тасалсан гишүүдэд орж байна аа. Ийм учраас хэдийгээр хуулиар 5-аас дээш хоног гарсан буюу 40 цаг давсан нэг гишүүн байгаа хэдий ч араас нь явж байгаа энэ гишүүд ч гэсэн энэ жилийн хувьд ирцдээ анхаарах нэн шаардлагатай гэдгийг бол сануулж албан тоотыг явуулсан болно оо.

Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10.7.3-д хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганы нэгдсэн, Байнгын, Дэд, Түр хорооны хуралдааныг тухайн жилд хуралдааны цахим ирцэд бүртгүүлсэн дүнгээр хоцорсон буюу тасалсан цаг нь ажлын 5 өдрийн цагаас дээш гарсан бол хариуцлага тооцох гээд Монгол Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх заалтад үндэслэн Баттулга гишүүнтэй бас уулзаж тайлбарыг бол тухайн үедээ авсан.

Цаашдаа бол Байнгын хорооны бидний хамтдаа гаргах шийдвэр нь Улсын Их Хурлын гишүүн Баттулгад Монгол Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын дагуу албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах саналыг бол би оруулж байна аа. Сахилгын хариуцлага тооцох нь зүйтэй гэдэг ийм саналыг оруулж байна.

Ер нь бол яг Баярбаатар дарга надад энэ даалгаврыг өгснөөс хойш ХМХ-ээр хамгийн өндөр таслалттай байгаа 2 гишүүнийг бол онцолж хэвлэлээр бол ярьж байсан. Бид ч гэсэн тухайн үедээ энэ 2 гишүүний нэрийг бол бас ярьж байсан. Баттулга гишүүнээс гадна Улсын Их Хурлын гишүүн Лүндэг тухайн үед бол тасалсан цаг 38 цаг байна гэж гарч байсан. Гэхдээ энд бол бас эмнэлгийн чөлөө акттай байсан.

Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т зааснаар хэдийгээр хариуцлага тооцох нөхцөл байдал үүсээгүй ч гэсэн лүндэг өөрөө албан ёсоор хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулаад би хувь хүнийхээ хувьд хариуцлагагүй хандаж эрүүл мэнддээ анхаарсангүй ээ, миний буруу уучлаарай гэдэг уучлалтыг бол олон нийтээс гуйсан байгаа.

Тэгээд цаашдаа ч гэсэн энэ ирцдээ анхаарна гэдэг ийм асуудлыг ярьсан байгаа учраас энийг бас энд дурдсан дурдсан нь зүйтэй байх гэж үзэж байна. Ер нь нэг тулгамдаж байгаа асуудал нь өөрөө юу юм бэ гэхээр тухайн одоо Улсын Их Хурлын хууль болон дэг болон энэ ёс зүйн дүрэм дээр ирцийн асуудлыг нэг талд нь тухайн жилдээ гэж байгаа боловчиг яг ирц маань өөрөө албан ёсоор нэгдсэн ээлжит чуулганыхаа нэг чуулганыхаа хугацаагаар гараад байдаг учраас аливаа ирцийг бүтэн жилээр нь авахлаар жоохон буруу юм шиг надад дүгнэгдлээ. Ийм учраас цаашдаа дүрмээ шинэчлэхдээ тухайн ээлжит чуулганыг авч үзэж тухайн жилдээ 2 удаа бас дүгнэх боломжтой байх. Аливаа ээлжит чуулганыг нэг бүтнээр нь авч үзэх

нь зүйтэй гэж үзэж байна. Тэгэхээр энэ дээр бол бас бид ажиллах хэрэгцээ шаардлагатай юм байна гэж үзэж байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулах нь Байнгын хорооны дарга танилцуулчих уу? Би ер нь бол танилцуулгаа хийж дууслаа. Та бүхэн маань тарагдсан тогтоолын төсөлтэй танилцана уу. Баярлалаа.

Б.Баярбаатар: Тогтоолын төсөл тарагдчихсан байгаа. Тэгэхдээ би уншаад танилцуулчихъя. Ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.5.7 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.7.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.7.3 дахь заалтыг зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулгад уг дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг баримтлан албан тушаалын цалингийн хэмжээг хэмжээг 3 сарын хугацаанд 20 хувиар бууруулах сахилгын хариуцлага ноогдуулсугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу? Лодойсамбуу гишүүнээр тасалъя. Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

Ч.Лодойсамбуу: 10 жилийн нөгөө нэг ариун цэврийн үзлэг эн тэр гэдэг шиг нэг тийм жоохон өрөвдөлтэй санагдаад байх юм. Тэр Лүндэг гишүүн яагаад хасагдчихсан гэнэ гэдэг нэг асуулт байна. Уучлалт гуйсан болохоороо юм уу, яасан учраас юм. Тэгээд ер нь бол Байнгын хорооны дарга, гишүүддээ бас уриалга хэлэх гээд байна. Бид нар энэ нэг ийм юу гэх юм. Багш нарын зөвлөлийн хурал шиг нэг ийм мэдээжийн хэрэг хариуцсан асуудал мөн үү мөн. Гэхдээ бид нарт бас анхаарах олон асуудлууд байгаа. Зүгээр сануулбал бид нартай энэ Их Хурлын үйл ажиллагааны дэг хамаатай. Их Хурлын үйл ажиллагаан дээр чуулганы нэгдсэн хуралдаан дээр дэг бол хэмжээ хязгааргүй зөрчигддөг. Хэмжээ хязгаар байхгүй. Горимын санал гаргаж байгаа байдал, чуулганы хуралдаан дээр хэлэлцэх асуудлыг оруулж ирж байгаа байдал, асуулт асуулгаж байгаа байдал, үг хэлүүлж байгаа байдал энэ үзэмжээр явдаг.

Санал хураалтыг жишээлбэл хэдийгээр Их Хурлын даргын бүрэн эрх хэдий ч гэсэн яг санал хураах гэхээр гишүүд нь байдаггүй. Гишүүд байхгүй байгаа учраас маргааш санал хураах гэдэг.

Тав дахид нэгдсэн байдлаар санал хураах гэдэг. Тэгээд ер нь байхгүй байж болох юм биш үү тэгэхээр. Яг тэр өдөр хэлэлцэх асуудлын дараалалд орчихсон асуудлыг хэлэлцээд санал хураалтад гишүүдийг дууддаг баймаар байна. Байнга суудаг гишүүд тэнд тэгээд юу хийж сууж байгаа юм. 1, 2 гишүүн ингээд нэг ийм ёс зүйн асуудал гээд л. Ингээд л энэнээс илүү хэдүүлээ нэг ийм Их Хурлын бүхэл бүтэн Байнгын хороо байна. Чуулганы нэгдсэн хуралдаан дээрээ дэгээ сахиулах, байгаа хуулиа мөрдүүлэх, энэн дээрээ Их Хурлын гишүүдийг илүү хариуцлагатай байлгах тал дээр анхаарч яривал илүү үр дүнтэй юм болов уу гэж бодож байна. Тэгээд

алагчлалгүй байя. Баттулга гишүүн бол суух ёстой. Гэхдээ миний санаж байгаагаар буруу санаагүй бол хурлуудад таслах эрхтэй, оролцох таслах эрхгүй оролцох гээд бас нэг зохицуулалт байдаг байх.

Лүндэг гишүүнийг яагаад хассан юм.

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн хариулах уу?

А.Ариунзаяа: Би түрүүн хэлсэн. Улсын Их Хурлын тухай хууль ёс зүйн дүрмээр тухайн чуулганы хуралдааныг 5-аас дээш хоног тасалсан блд 5-аас дээш хоног гэдгийг 40 цагаар тооцож байгаа. 40-өөс дээш цаг гарах юм бол хариуцлага тооцох ногдуулах ийм асуудал байгаа. Би цаг минутаар нь танилцуулъя. Энэ бол зөвхөн 12 сарын 27-ноор таслагдаж байгаа мэдээ. Улсын Их Хурлын 2024 оны анхдугаар ээлжит бус намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны 12 сарын 27 хүртэлх мэдээ. Нийт хуралдсан цаг 162 цаг 49 минут.

Тасалсан 1 дүгээрт Халтмаагийн Баттулга 67 цаг 20 минут, 2-т Сүрэнжавын Лүндэг 38 цаг 37 минут, 3 дугаарт Энхтайваны Батамгалан 32 цаг 30 минут, 4 дүгээрт Норовын Алтанхуяг 30 цаг 33 минут, 5 дугаарт Мөнхтөрийн Нарантуяа нараа 21 цаг 53 минут, 6 дугаарт Дамбын Батлут 20 цаг 11 минут, 7 дугаарт Дашдондогийн Ганбат 19 цаг 35 минут, 8 дугаарт Очирбатын Амгаланбаатар 16 цаг 25 минут, 9 Далайн Батбаяр 16 цаг 4 минут, 10 Даваагийн Цогтбаатар 14 цаг гээд эхний 10 хүнд бас сануулах албан тоот явуулсан. Энэ 10 хүнийг ч гэсэн энд эхний ээлждээ зарлах нь зүйтэй. Хэн нэгнийг сугалж авч үлдсэн асуудал байхгүй. Гагцхүү хуулиар хүлээлгэх 40 цагийн хязгаарыг давсан байгаа нэг хүн байгаа учраас үүнийг хариуцлага тооцох ийм асуудлыг оруулж ирж байгаа. Ер нь бол яг ийм юм яриад сууж байгаа гэдэг нь бол инээдтэй гэдэгтэй санал нэгдэж байна аа. Жоохон хүүхдүүд байгаа биш дээ тангаргаа өргөөд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон л бол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан гэлтгүй Байнгын хороо, ажлын хэсэг, бусад хуралдаандаа цаг хугацаандаа оролцох ёстой. Гадаад томилолт, дотоод томилолт, өвчтэй асуудлуудыг бол ямар нэгэн байдлаар өөр ажил давхцаж байгаа гэдгийг бол хүлээн зөвшөөрнө өө. Огт тийм асуудал байхгүй байна гэдэг асуудал биш. Гагцхүү чөлөөгөө авах ёстой, мэдэгдэх ёстой бусдынхаа ажил цагийг бас хүндлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байна аа. Баярлалаа.

Б.Баярбаатар: Хариулт болсон уу? Лодойсамбуу гишүүний гаргаж байгаа саналтай санал нэг байгаа. Тэгэхдээ одоо өнөөдөр бид нар энэ инээдтэй ч гэх юм уу энийг ярихаас өөр аргагүй шүү дээ. Тэгээд хуралдаа суухгүй байгаа юм чинь яах юм? Яах гэж тэгвэл тэр иргэдийн саналыг авч энэ парламентын гишүүн болсон юм. Өөр ажлаа хийгээд л яв л даа тэгээд. Дээр нь одоо би энэ Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулга хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагыг үзлээ. Би ирдэг, энэ төхөөрөмж болдоггүй юм гэж. Юм л бол нөгөө хойд хар овоохой гэдэг шиг энэ санал хураалтын төхөөрөмж, энэ бүртгэлийн төхөөрөмж рүү чихдэг асуудлаа болих хэрэгтэй, болих хэрэгтэй. Нэг том агуулгаараа ярих юм бол энэ Монгол Улсын парламентыг үл хүндэтгэсэн байдал шүү ер нь бол. Тэнд өөдөөс нь бараг 70, 80 Улсын Их Хурлын гишүүн өөдөөс нь хараад сууж байна. Бүгд эс үгүй бол сохор болчихсон юм уу? Мэдэхгүй харагддаггүй шүү дээ, тэр хүн чинь. Эс үгүй бол үл үзэгдэгч тийм малгай өмсөж орж ирдэг юм уу?

Иймэрхүү байдлаар ийм танхимд байгаа Улсын Их Хурлын гишүүдээ, сонгосон сонгогчдодоо Монгол Улсын парламентыг ингэж ийм үл хүндэтгэсэн ийм

доромжийн шинжтэй асуудлыг ярьж болохгүй байх аа. Өнөөдөр бас хариуцлагатай албан тушаал гэж бодож байгаа. Ийм учраас би ажлын хэсгээс оруулж ирсэн 3 сар гэдэг саналыг би 6 сар болгож нэмэгдүүлэх санал оруулж байна. Энийг гишүүд дэмжиж өгөхийг хүсье. Ажлын хэсэг Ариунзаяа гишүүн бол 3 сар 20 хувь гэж оруулж ирж байгаа бол би энийг 6 сар 20 хувь гэдэг саналын томьёолол оруулж байна.

Санал хураалгана, дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Тэгвэл Байнгын хорооны даргын зүгээс гаргасан 3 сарын хугацаанд 20 хувиар цалин бууруулах сахилгын хариуцлагыг 6 сарын хугацаанд 20 хувиар гэж өөрчлөх саналыг гаргаж байна. Саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Асууж болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрэм гэж байна аа. Энэ дээр нөгөө 3 хариуцлага ноогдуулдаг шүү дээ. 1 дүгээрт сануулдаг, 2 дугаарт уучлалт гуйх, 3 дугаарт зургаа хүртэл сар цалингийн 20 хувиар. Хүртэл гэж байгаа шүү. Нэг сар ч байж болно, 4 сар ч байж болно, 5 сар ч байж болно, 6 сар ч байж болно.

Санал хураалт.

Санал хураалтад 7 хүн оролцож, 4 гишүүн дэмжсэнээр 57.1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг би та бүхэнд. Бадарчийн Хэрлэн гишүүн дэмжсэнээр оруулж ирэхийг хүсэж байна оруулъя. Ингээд нийтдээ 5 гишүүн дэмжлээ.

Ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.5.7 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 105-д дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.7.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.7.3 дахь заалтыг зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулгад уг дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг баримтлан албан тушаалын цалингийн хэмжээг 6 сарын хугацаанд 20 хувиар бууруулах, сахилгын хариуцлагыг ногдуулсугай гэсэн байна аа.

Тогтоолын төслөө баталъя гэсэн санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 8 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, Хэрлэн гишүүн дэмжсэнээр орж байна уу тиймээ. Ингээд 7 гишүүн дэмжиж 75 хувиар тогтоол батлагдлаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хурал төлөвлөсөн асуудлаа хэлэлцэж дууслаа. Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Хурал өндөрлөлөө.

14.54 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА